



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/483

Арвайхээр

**Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "в", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жил, аймаг байгуулагдсаны 88 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хүрээнд хэв журмын асуудал хариуцсан салбар хороо нь наадмын талбайн орчмын автомашины түгжрэлийг сааруулах, замын хөдөлгөөний дэг журмыг хангах зорилгоор автомашины А, Б, В, Ү, мотоциклийн зөвшөөрлийн хуудсыг хариуцан гаргаж ажиллахыг зөвшөөрсүгэй.

2. Баяр наадмын үеэр наадмын талбайн орчимд зорчих автомашины А, Б, В, Ү, мотоциклийн зөвшөөрлийн хуудасны үнэ, тоо, ширхэгийг хавсралтаар баталсугай.

3. Зөвшөөрлөөс олсон орлогыг нийтийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд зарцуулахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баяр наадмын зохион байгуулах хорооны дарга (И.Доржсүрэн), аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100842

Аймгийн Засаг даргын 2019... оны ...  
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



АВТО МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗОРЧИХ ЗӨВШӨӨРЛИЙН  
ХУУДАСНЫ ТОО

№	Зөвшөөрлийн хуудасны төрөл	Тоо ширхэг	Үнэ
1	А зөвшөөрлийн хуудас	30 ш	20000
2	Б зөвшөөрлийн хуудас	200 ш	10000
3	В зөвшөөрлийн хуудас	50 ш	10000
4	Мотоциклийн зөвшөөрлийн хуудас	20 ш	3000
5	Ү зөвшөөрлийн хуудас	10 ш	үнэгүй

-oOo-